4	1 м3 элс угаахад шаардагдах технологийн усны зарцуулалт		м ³	4	4	4	4	4	х
5	Хоногт угаах элсний хэмжээ			656.6	656.6	656.6	656.6	656.6	
6	Дахин ашиглах усны хэмжээ		%	70	70	70	70	70	х
7	Цэвэр ус нөхөн сэлбэх хэмжээ		%	30	30	30	30	30	х
8	Өдөрт шаардагдах усны хэмжээ	Дахин ашиглах	м ³	1,838.48	1,838.48	1,838.48	1,838.48	1,838.48	Өдөрт ашиглах усны хэмжээ-2626.4 м ³
		Цэвэр ус сэлбэх	м ³	787.92	787.92	787.92	787.92	787.92	
9	Жилд шаардагдах усны хэмжээ	Дахин ашиглах	м ³ / жил	140,000	140,000	140,000	140,000	130,256	690,256
		Цэвэр ус сэлбэх	м ³ / жил	60,000	60,000	60,000	60,000	55,824	295,824
Жилд шаардагдах усны хэмжээ, м ³									986,080

Төслийн үйл ажиллагаанд 2 төрлийн хугацаат ажил байгаа нь уурхайн олборлолт болон баяжуулах үйлдвэр гэсэн ялгаатай 2 талбайд өөр өөр хугацаанд үйл ажиллагаа явуулах юм. Эхнийх нь уул уурхайн олборлолт. Энэхүү ажил нь хаврын улирлаас эхлүүлэн намрын сүүл сар хүртэл үйл ажиллагаа явуулж нийт 165 өдрийн турш олборлолтын ажил хийгдэнэ. Харин төслийн угаан баяжуулах гэсэн хэсэг нь олборлолтын үйл ажиллагаанаас арай өөр хугацаанд буюу олборлолтын хугацаанд хөрс хуулалтын ажил болон засвар үйлчилгээ хийх өдөр зэргээс шалтгаалан **77 өдөр 2 ээлжээр өдөрт 4-10 цагаар ажиллахаар** төлөвлөсөн байна.

БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1. Физик газарзүй

“Төсөлч” ХХК-ний Туул голын баруун дэнж нэртэй алтны шороон орд нь Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт Улаанбаатар хотоос 265 орчим км, Бүрэгхангай сумаас 42 км зайд байрлаж байна. MV-016841 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Туулын баруун дэнжийн алтны шороон ордыг ашиглах” төслийн талбай нь засаг захиргааны харьяаллаар Булган аймгийн Бүрэгхангай сумын 3 дугаар багийн нутагт орших Бүрэгхангай сумын төвөөс зүүн зүгт 34 км, “Шижир алт” сууринаас 3.6 км зайд Туул голын дагуу байрлана.



Зураг 3. Төслийн талбайн байршлын физик газарзүйн мужлал

Физик газарзүйн мужлал гэдэг нь газар орныг байгалийн бүхий л нөхцөл буюу геологийн бүтэц, хотгор гүдгэр, уур амьсгал, ус зүй, хөрс, ургамалжил, амьтны аймгийн хам бүрдлийн талаар өөр хоорондоо тодорхой ялгаатай хэсгүүдэд хуваах явдал юм. MV-016841 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Туулын баруун дэнжийн алтны шороон ордыг ашиглах” төслийн талбай нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Хангай-Хэнтийн уулархаг их муж (II), Хангайн муж (II.1)-ийн Сэлэнгэ Орхоны савын дундаж өндөртэй уулсын тойрогт хамаарна. Харин байгалийн байгалийн бүс бүслүүрээр Уулын ойг хээрийн бүслүүрт хамаарна. Газрын гадаргын хувьд дундаж өндөртэй нам уулс хоорондын Туул голын хөндийд орших бөгөөд гадаргуугаас 900-1000 м үнэмлэхүй өндөрт байрлана.

2.2. Цаг уур, уур амьсгал

Төслийн талбай байрлах Булган аймгийн Бүрэгхангай сумын уур амьсгалын үндсэн нөхцөлийг тодорхойлохын тулд тус суманд орших цаг уурын Бүрэгхангай станцын мэдээг ашиглан боловсрууллаа.

Булган аймаг нь Хангайн нурууны салбар бэсрэг уулс Хантай, Булган хан, Ханжаргалант, Дулаан хан, Намнан, Хутаг-Өндөр, Онгон сарьдаг, Сардиг Бүтээл, Бөхөн шарын нуруу, Бүрэн хан, Могодын нуруу, Авзага хайрхан, Бүрэгхангай, Дулаан хар, Хөгнө хан, Лах баян, Өрхтэй, Баянзүрх, Баян-Агт зэрэг 2000 метрээс дээш өргөгдсөн өндөр уул нуруудтай. Хамгийн өндөр цэг нь Хантай нурууны оргил Давлан 2171 метр, хамгийн нам дор газар нь Сэлэнгэ мөрний сав Сүмийн Булан, Итгэттолгой орчим далайн түвшнээс дээш 950 метрт оршдог.

Газар нутгийн тэгш бус байдал, өвс ургамалтай болон ургамалгүй гадарга, гол мөрөн, уул нуруу, хотгор, хөндий, тэгш тал алаглан оршдог явдал нь тухайн нутгийн уур амьсгалын өвөрмөц нөхцөлийг бүрэлдүүлэх үндсэн шалтгаан болдог.

Агаарын температур

Булган аймгийн уур амьсгал нь манай орны уур амьсгалын эх газрын эрс тэс шинж шинжтэй. Агаарын температурын хамгийн их ба бага утга 7-р сард, 2-р сард илэрнэ. 7-р сарын агаарын хамгийн их температурын утга нь 30.8°C, 2-р сарын агаарын температурын хамгийн бага утга нь -31.1°C байна.

Хур тунадас

Төслийн хэрэгжих талбай орчмын нутаг нь хур чийг бага, хуурайшил ихтэй бүсэд багтаж жилийн нийлбэр хур тунадас нь 411.9мм, дулааны улиралд 399.1мм, хүйтний улиралд 12.8мм байна. Хур тунадас нь зуны улиралд зонхилон тохиолдох бөгөөд энэ нь нийт хур тунадасны 90-95%-ийг эзэлнэ. Хур тунадасны жилийн нийлбэрийн олон жилийн өөрчлөлтийг авч үзэхэд хур тунадасны жилийн нийлбэр төсөл хэрэгжих бүс орчмоор сүүлийн жилүүдэд маш бага хэмжээгээр буурсан хандлагатай байна.

Салхины горим

Булган аймгийн хувьд салхи голдуу хойт ба баруун хойт зүгээс зонхилон салхилна. Салхины чиглэлийн давтагдал жилийн аль ч сард хойт, баруун хойт чиглэл 30-40% давтагдалтай байхад зүүн чиглэлийнх нь бараг давтагдалгүй байна. Салхины үнэмлэхүй их хурдны хамгийн бага утга нь 1-р сард бөгөөд салхины хурд 10м/с байна.

Төсөл хэрэгжих бүс орчмоор салхины үнэмлэхүй их хурдны жилийн дундаж их хурд 17.2м/с байна. Салхины хурдны их утга нь хаварын улиралд ажиглагдах бөгөөд 2-6 дугаар сард 16м/с-21м/с хүрдэг байна. Өвлийн улиралд салхины хурдны бага утга нь ажиглагдана.

Агаарын чийгшил ба хур тунадасны горим

Төсөл хэрэгжих талбай нь чийглэг уур амьсгалтай бүсэд багтаж жилийн нийлбэр хур тунадас нь 411.9мм, дулааны улиралд 399.1мм, хүйтний улиралд 12.8мм байна. Хур тунадас нь зуны улиралд зонхилон тохиолдох бөгөөд энэ нь нийт хур тунадасны 90-95%-ийг эзэлнэ. Хур тунадасны жилийн нийлбэрийн олон жилийн өөрчлөлтийг авч үзэхэд хур тунадасны жилийн нийлбэр төсөл хэрэгжих бүс орчмоор сүүлийн жилүүдэд маш бага хэмжээгээр буурсан хандлагатай байна.

Нарны гийгүүлэл

Төсөл хэрэгжих талбай орчим дулаан улиралд нарны гийгүүлэл уртсаж, цацрагийн эрчим ихтэй байдаг нь нараар нөхөн сэргээх, чийрэгжүүлэх боломж ихтэй.

Нарны гийгүүлэл жилдээ 2733 цаг үргэлжилдэг нь боломжит хугацааны 60% орчмыг эзэлдэг орчны уул зүй, өглөө оройн нарны халхлагдах болон хот орчмын үүлшил, агаарын булингаршил, хотын цаг агаартай холбоотой буурдаг. Нарны гийгүүлэл хоног, сар, жилийн хугацаагаар цэлмэг үед нэн тодорхой явцтай байна. Нэг өдөрт дунджаар жилдээ 7-8 цаг нар гийгүүлэхдээ үүлшлээс хамаарч хэлбэлзэх боловч зуны саруудад 8.5-9.6 цаг, өвлийн саруудад богиносж 5-6.5 цаг нартай байдаг.

2.3.Төслийн талбайн геологийн судалгаа

Уурхайн талбай нь хойд Монголын атираат системийн Тариат Сэлэнгийн структур-формацийн бүсүүдийн заагийг дамжин байрлах ба металлогений бүсийн хувьд Заамарын хүдрийн зангилгаанд хамаарна.

Давхарга зүй


Давхарга зүйн хуримтлал нь уурхайн талбайн ихэнхи хэсгийг эзлэх бөгөөд Эрт төрмөлийн эринээс Шинэ төрмөлийн үеийг хүртэл насны заагийг хамарсан, ихэнхи төлөв терриген гаралтай хурдас үүссэн байдаг.

Талбайн давхарга зүйн ангилалд доорхи хурдас хуримтлал ялгагдана.

1. Дунд кембрийн-Доод ордовик. Хараагийн сери-доод буюу Заамарын свит, Дээд буюу Доргонтын свитийн флиш маягийн терриген хуримтлал.
2. Триасын. Авзагын формацийн моласс маягийн терриген хурдас
3. Цэрдийн. Зүүнбаянгийн формацийн-нүүрслэг занар. Алевролит. Аргиллит.
4. Шинэ төрмөлийн эрин. Негоны галав. Доод хэсэг-хүрмэн чулуу. Дунд дээд хэсэгшар өнгийн элс хайрганы хуримтлал. Дээд хэсэг улаан өнгийн шавар.
5. Дөрөвдөгчийн галав-аллюви, бэл, хажуугийн гаралтай хурдас

2.4.Гадаргын усны судалгаа

Усан сүлжээ сайн хөгжсөн. Хамгийн том гол нь Орхон голын баруун цутгал болох 600км орчим урттай, 1-4 км өргөн хөндий бүхий Туул гол юм. Туул голын гольдрол нь тохойрол, тахирлалт ихтэй, олон тооны хар ус, жижиг аралтай бөгөөд гольдролын өргөн нь. 30-100 м, гүн нь 0.5-1.6 м зарим газраа 2.5 м хүрдэг. Урсгалын хурд 0.3-11 м/сек, хөндийн хэвгий 0.001-0.002, Туул голын зүүн цутгал болох Цагаан-булаг,Тосон зэрэг хөндийнүүд нь байнгын урсгал устай байдаг. Мөн уурхайгаас урагш 30 км-т Туулын баруун цутгал болох Харбухын гол байдаг.



Зураг 4. Төслийн талбайн байршилтай хамгийн ойр байрлах голын сүлжээ

Төслийн талбайн байршилд хийсэн судалгаагаар тухайн төслийн талбайн байршил нь гадаргын уст цэгтэй давхцалгүй буюу хамгаалалтын бүсээр давхцалгүй байх ба Туул голоос 38-254.7 метр зайд оршиж байна.

2.5. Гидрогеологи

Судалгааны талбай нь гидрогеологийн ангиллаараа Хангай, Хэнтий гидрогеологийн тогтцод хамаарна. Хайгуулын ажил явуулсан талбайд ус агуулагч хурдасны геологилитофизи болон структурын онцлог, газрын доорх усны гарал үүсэл, тэдний химийн найрлагыг харгалзан дараах уст давхрага бүрдлүүдийг ялгаж болно.

1. Дөрөвдөгчийн настай хучаас хурдасны уст бүрдэл
Энэ нь дотроо:
 - а. Голын хурдасны
 - б. Бэл-хормойн /делюви-пролюв/
 - в. Нуур намгийн хурдасны уст давхаргууд гэж хуваагдана.
2. Мезо-Кайнозойн (дунд-шинэ төрмөлийн) сэвсгэр ба хатуурсан хурдасны уст бүрдэл
3. Ан цавын ус агуулагч бүрдэл
4. Гадаргуугын ус

2.6. Хөрсний судалгаа

Хөрсний мужлал

Хэнтийн муж энэ мужид Хэнтийн нуруу хийгээд түүний салбар уулс, Орхон, Туул, Хараа, Ерөө голын хөндий, мөн Эрээний нуруу, Онон, Улзын сав газар багтана. Тус мужийн төв хэсэгт хамгийн өндөр өргөгдсөн (үнэмлэхүй өндөр нь 2400-2750 м) Хэнтийн гол нуруу орших бөгөөд түүнээс тал бүр тийш салбарласан уулс аажим намссаар бэсрэг уулс болон улмаар ухаа гүвээт талд шилжинэ.


Хэнтийн мужийн хөрсний босоо бүсшилийн бүтцийг доор авч үзье.

Уулын ар хажууд 1400 метрийн үнэмлэхүй өндөр хүртэл хар хүрэн, хүрэн хөрс, 1400-1600 метрт уулын хар шороон хөрс, түүнээс дээш 1800-2000-2400м хүртэл уулын ойн саарал ба уул тайгын ширэгт-чандруувтар хөрс тус тус тархаж, уулын хавтгайдуу оройд уулын нугын хүлрэнцэр нимгэн хөрсөөр солигддог ажээ.

Харин уулын ой модоор хучигдаагүй өвөр хажууд, Хэнтийн уулс дотроо бол (доороос дээш) хүрэн, хар хүрэн хөрс аажмаар хар шороон хөрсөнд шилжиж, тэр нь 1600-1700 м-ийн өндөрт заримдаг тагийн уулын нугын хар шороорхуу хөрсөөр солигдоно.

Гэтэл Хэнтийн урд захын уулсын говь руу харсан энгэр талд хүрэн хөрс бүр уулын орой хүртэл туждаа үргэлжилдэг байна.

Ер нь уулт-тайгын ширэгт-чандруувтар ба нуга намгийн хөрс их хөгжсөн Хэнтийн төв хэсгээс гадагш захруугаа явах тутам хуурай хээрийн нөлөө ихсэж, хар хүрэн хөрс эрс нэмэгдэхийн зэрэгцээ, хужир марзтай хонхрууд бий болж ирнэ.



Зураг 5. Төслийн талбайн хөрс газарзүйн мужлал

Төслийн талбайн хөрс нь газарзүйн мужлалаар Хангайн их муж хар хүрэн, хүрэн хөрсний дэд бүсэд багтах бөгөөд Судалгаа хийсэн газар нь уулын хүрэн, уулын хар хүрэн, аллювийн нуга намгийн хөрсний хэв шинжүүд тархсан байгаа тогтоолоо.

2.7. Ургамлын төрөл зүйлийн судалгаа

“ТӨСӨЛЧ” ХХК-ний Туул голын баруун дэнж нэртэй ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй төслийн үйл ажиллагаа явуулах хугацаанд ургамлан нөмрөг тодорхой хэмжээгээр талхлагдаж, доройтсон тул төсөл хэрэгжих талбайн ургамлын нөмрөгийн төлөв байдлын судалгааг хийж гүйцэтгэв.


Ургамлын ангиллын үндсэн бүлгийн бүтэц. Уг талбайд бүртгэгдсэн зүйл ургамлын ангиллын үндсэн бүлгүүдийн бүтцийг авч үзэхэд ойм, шивэрсэн, шивлээ, нүцгэн үртэний хүрээний хүрээний зүйл ургамалгүй, далд үртэний хүрээний 37 зүйл (үүнээс нэг талтан 8 зүйл, хос талтан 29 зүйл) байна

2.8. Төслийн талбайн байршилд хийгдсэн амьтны тархалт судалгаа

MV-016841 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “туул голын баруун дэнж алтны шороон ордыг ашиглах” төслийн талбай байрлах Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг дэвсгэр нь Монгол орны амьтны аймгийн газарзүйн мужлалаар Монгол Дагуурын тойрогт хамаарна. Дээрх судалгааны материалуудаас үзэхэд энэ бүс нутгийн амьтны аймагт нийт 11 багийн 280 гаруй зүйл шавж, 1 зүйл хоёр нутагтан, 1 зүйл мөлхөгч, 13 зүйл загас, 140 зүйл шувуу, 39 зүйлийн хөхтөн амьтан бүртгэгдэж байсан байна (Мөнхбаяр, 1976; Дуламцэрэн нар, 1989)

2.9. Тусгай хамгаалалттай газар

MV-016841 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Туул голын баруун дэнж алтны шороон ордыг ашиглах” төслийн талбай байрлах Булган аймгийн нутаг дэвсгэрт улсын тусгай хамгаалалттай Дархан цаазат газар (ДЦГ) 1, Байгалийн цогцолборт газар (БЦГ) 1, Байгалийн нөөц газар (БНГ) 2, Дархан газар (ДГ) 1 орших боловч Бүрэгхангай сум болон төслийн талбайн ойр орчимд Улсын тусгай хамгаалалттай газар нутаг байхгүй байна.



Зураг 6. Булган аймгийн ТХГН байхшил

2.10. Палеонтологийн хайгуул, тандан судалгааны ажлын дүгнэлт

"Төсөлч" ХХК-ны тусгай зөвшөөрлийн талбайд палеонтологийн олдворын ул мөр ажиглагдаагүй байна. Түүнчлэн археологийн дурсгал илрээгүй байна. Уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.

2.11. Нийгэм эдийн засаг Булган аймгийн Бүрэгхангай сум

Бүрэгхангай сум нь 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын дараагаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн зохион байгуулалтад өөрчлөлт орж ардын засгийн газраас шинээр гаргасан нутгийн захиргааны дүрэмд орон нутгийн захиргааг арван гэр, баг, сум, хошуу, аймаг болгон хувиарлахдаа 1923 онд Түшээт хан аймгийн Жонон гүний хошууг Богд Хан уулын аймгийн Шажин-Бүрэг/Сазан Бүрэг/ уулын хошуу болгон Их дулаан, Баянхангай, Заамар гэсэн 3 сумтайгаар байгуулж хошуу даргаар мээрэн Жамьяндоржийг сонгожээ.

Бүрэгхангай сум нь Улаанбаатар хотоос 265 км, Булган аймгийн төвөөс 86 км зайд оршдог. 349792 га газар нутагтай, үүнээс 282109 га нь бэлчээр, 10564 га нь хадлан 4361 га нь тариалангийн талбайд тооцогдож байна. Орхон ба Төв аймгийн Заамар сумтай хил залгаа оршдог. Тус сумын Бичигтийн голд Монголдоо томд тооцогдох хадны сүг зураг байдаг. Бүрэгийн нуруу, Дархан, Баянхангай, Шувуут, Их дулаан, Бага дулааны тахилгат хошуу 6 овоо, Шар хадны нуруу, Алтанга, Хутаг, Загзага, Эрдэнэ уул, Цоохор морьт зэрэг уулс, Орхон Туул зэрэг томоохон гол байдгаас гадна Ангирт, Шувуут, Бичигт, Хужирт, Хар бух гэх мэт 30 орчим гол горхи Булаг шанд, Дэлгэржаргалат, Ум, Хадат булгийн рашаанууд байдаг.

БҮЛЭГ 3. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУРААНГУЙ

Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд түүнд өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд тухайлбал газрын гадарга, хэвлий, агаар, гадаргын болон газрын доорх ус, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймаг, тусгай хамгаалалттай газар нутаг, түүх соёлын дурсгал, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэдийн нийгмийн байдал, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг чиглэл бүрээр нь гаргаж уг бүлэгт тусгасан болно. Мөн тэдгээр гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн эрчим, тархалт, хэмжээг тодорхойлж, тоон ба чанарын үнэлгээг өгсөн болно.

3.1.Төслөөс хөрсөн бүрхэвчид учруулах нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаанаас үүсэх хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл нь тухайн төслийн үйл ажиллагааны онцлогоос хамаарч үзүүлэх нөлөөлөл нь тодорхойлогдоно. Тухайн нөлөөллүүд нь ахуйн зориулалттай ажилчдын хотхоны ашиглалт, уул уурхайн олборлолт, уурхайн авто тээвэрлэлт, хөрс тээвэрлэлт, дотоод гадаад зорчилт хөдөлгөөн, уурхайн бусад үйл ажиллагаа, энгийн, аюултай хог хаягдал, ахуйн бохир гэх зэргээр олон янзаар хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл бий болох магадлалтай. Гэхдээ тодорхой хэсэг газруудад магадлалтай бус зайлшгүй нөлөөлөл үзүүлэх хүчин зүйлс байх болно. Энэ нь уул уурхайн олборлолт, хөрс хуулалттай холбоотой болон зам ашиглалттай холбоотой нөлөөлөл байна. Харин бусад нөлөөллөөс урьдчилан сэргийлэх боломжтой ба нөлөөллийг бууруулах боломжтой болох юм.

“Төсөлч” ХХК-ийн үйл ажиллагаа явуулж буй талбайн байршил нь одоогоор нийт нөлөөлөлд өртчихсөн байгаа талбайн хэмжээ нь 32.7 га талбай байх ба харьцангуй эрүүл, бага эвдрэлд өртсөн буюу сул доройтсон талбайн хэмжээ нь 20.6 га байна. Одоогоор тухайн талбайд үйл ажиллагаа явуулах талбайд эрүүл буюу бага эвдрэлд өртсөн талбайн ашиглалт хийхгүй ба олборлолтын талбай нь бүхэлдээ эвдрэлд орж нөөц дутуу авсан хэсгийн талбайд дахин олборлолт хийхээр төлөвлөсөн ба 100 % ашиглалтад өртсөн талбай байна.

3.2.Төслөөс ургамлан нөмрөгт учруулах нөлөөлөл

Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт “Төсөлч” ХХК-ийн уурхайн зориулалтаар ашиглаж байгаа 53.36 га талбай дахь ургамалжлын өнөөгийн төлөв байдал ба доройтол. Уг талбайн ургамлан нөмрөгийн өнөөгийн төлөв байдлыг гаргахад чулуутай 51 га, довонтой 2 га, 20.6 га өвслөг ургамалтай байна.

Ач холбогдол ба хор холбогдол	Ангилал зүйн нэгж			Эзлэх хувь
	овог	төрөл	зүйл	
Бэлчээр тэжээлийн ургамал	13	27	35	94.59%
Эмийн ашигт ургамал	11	15	19	51.35%
Хөл газрын ургамал	10	12	18	48.64%

Бэлчээрийн ургамлаас малд сайн идэмжтэй Крыловын хялгана (*Stipa Krylovii* Roshev.) зонхилж, Саман ерхөг (*Agropyron cristatum* (L.) P.B.), Мөлхөө хиаг (*Elytrigia repens* (L.) Desv. ex Nevski.), Шар царгас (*Medicago falcata* L.), Тарваган харгана (*Caragana pygmaea* (L.) DC.), Агь (*Artemisia frigida* Willd.), зэрэг ургамлууд байна.

Ургамал хамгаалал. Ургамал судлаач У.Лигаа, Ш.Дариймаа, П.Цэрэннадмид, төслийн багийн гишүүд Н.Жанчивдорж, У.Сарангэрэл, Б.Бат-Энэрэл нарын хамт (2008 онд) Монгол орны нэн ховор ургамлын зурагт лавлахад 53 овог, 99 төрлийн 133 зүйл ургамал бүртгэсэн байдаг. 2009 онд У.Лигаа ахлагчтай эрдэмтэн судлаач Ш.Дариймаа, Н.Жанчивдорж, У.Сарангэрэл, Х.Жамъяндорж, Б.Бат-Энэрэл нар Монгол орны ховор ургамлын зурагт лавлахад 355 зүйл ховор ургамлын ангилал зүй, таних шинж, тархац, ургах орчин, үржил, нөөц хомсдох шалтгаан, хамгаалах арга хэмжээ зэргийг бичсэн байна.

Дээрх судлаачдын бүтээлийн дагуу Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт “Төсөлч” ХХК-ийн уурхайн зориулалтаар ашиглаж байгаа 53.36 га талбайн дотор ургаж байгаа нэн ховор, ховор, унаган, үлдэц ургамлын бүртгэлийг гаргахад нэн ховор, ховор ургамал, үлдвэр, Монголын унаган ургамал бүртгэгдээгүй, Монголд байгаа завсрын унаган ургамал Цагаан хунчир (*Astragalus galactites* Pall.), Монгол шарилж (*Artemisia mongolica* Fisch. ex Nakai.) гэсэн 2 зүйл бүртгэгдсэн байгаа нь бүх ургамлын 4.8% нь хамгаалалтад авах шаардлагатай ургамалд багтаж байна.

Хүснэгт 28. Уурхайн зориулалтаар ашиглаж байгаа 53.36 га талбай дахь зүйлийн бүрдлийн онцлог

Ургамал хамгааллын статус	Ангилал зүй			Эзлэх хувь
	Овог	Төрөл	Зүйл	
Нэн ховор ургамал	0	0	0	0.0%
Ховор ургамал	0	0	0	0.0%
Монголын унаган ургамал	0	0	0	0.0%
Монголд байгаа завсрын унаган ургамал	2	2	2	4.8%
Үлдэц ургамал	0	0	0	0.0%
Бүгд				4.8%

Хүснэгт 29. Ургамлан нөмрөгийн төлөв байдал ба доройтол

№	Дээж	Талбайн хэмжээ, га	Ургамалжлын бичиглэл				
			Ургамлын бүрхэц, %	Олшрогч ургамлын бүрхэц, %	Талхлагдлын заагуур ургамал	Халцгай газрын хэмжээ, %	Доройтлын зэрэг

1	Хялгана-шарилжит (110a/ X-I-2-9)	12 га	53.8	14.8	Цагаан хунчир (<i>Astragalus galactites</i> Pall.), Ширэг улалж (<i>Carex duriuscula</i> C.A.Mey.), (<i>Artemisia frigida</i> Willd.), Адамсын шарилж (<i>Artemisia Adamsii</i> Bess.), Шүүрэн шарилж (<i>Artemisia scoparia</i> Waldst. et Kit.), Шүлхий шарилж (<i>Artemisia pectinata</i> Pall.), Өнхрүүш хамхуул (<i>Corispermum declinatum</i> Steph.), Цэх түмэн тана (<i>Chamaerhodos erecta</i> (L) Bge.), Их далантовч (<i>Androsace maxima</i> L.), Бага хургалж (<i>Eragrostis minor</i> Host)	39.2	Дунд зэрэг доройтсон
2	Хялгана-хиаг-агьт (105a/ X-I-2-4)	8.6 га	61.2	16.0	(<i>Carex duriuscula</i> C.A.Mey.), Ишгүй гичгэнэ (<i>Potentilla acaulis</i> L.), Арзгар согсоолж (<i>Heteropappus hispidus</i> (Thunbg.) Less.), Цуулбар багваахай (<i>Taraxacum dissectum</i> (Ldb.) Ldb.), Цагаан хунчир (<i>Astragalus galactites</i> Pall.), Адамсын шарилж (<i>Artemisia Adamsii</i> Bess.), Шүүрэн шарилж (<i>Artemisia scoparia</i> Waldst. et Kit.), Өнхрүүш хамхуул (<i>Corispermum declinatum</i> Steph.), Бөөн цэцэгт цангуу (<i>Lepidium densiflorum</i> Schrad.), Монгол шарилж (<i>Artemisia mongolica</i> Fisch. ex Nakai)	32.0	Дунд зэрэг доройтсон
3	3-р нэгж талбар	15 га	-	-	-		Хүчтэй доройтсон газар
4	4-р нэгж талбар	17.1 га	-	-	-		Хүчтэй доройтсон газар

5	5-р нэгж талбар	0.66 га	-	-	-	Мод тарьж нөхөн сэргээсэн
Нийт		53.36 га				

3.3.Төслөөс ус орчинд учруулах нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаатай холбоотой нөлөөллийн үнэлгээнд багаас дунд шатны нөлөөллийн хэлбэр бий болохоор байгаа бөгөөд урт зайлшгүй нөлөөллийн хэлбэрүүд нь богино хугацааны нөлөөлөл байх ба санамсар, болгоомжгүй байдлаас, эсвэл хүний(ажилчдын) буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй болзошгүй байдлаар үүссэн нөлөөллийн хэлбэр нь урт хугацааны сөрөг нөлөөлөл үзүүлэхээр байна. Эдгээр нөлөөллүүд нь багаас дунд хэмжээний талбайд нөлөөлөл үзүүлэх хэдий ч энэ нь тухайн орчиндоо нөлөөллийн хэлбэр нь хүчтэй байхаар байна.

- Төслийн үйл ажиллагаанаас үүсэх шавхан зайлуулалтын үеийн процесс нь ихэвчлэн тухайн төслийн олборлолтын шатанд үүсгэсэн карьер олборлолтын ажлын үед уурхайд шүүрлээр ус шүүрэн орж ирэх ба тухайн усанд үйл ажиллагааны шатанд аливаа байгалийн гаралтай умбуур бодис болон бусад элиментээр бохирдох магадлалтай. Тухайн усыг уурхайн угаан баяжуулах ажил буюу алт агуулсан элсийг угаах ажил хийж гүйцэтгэх ба бохирдох магадлалтай зүйл нь угаан баяжуулах үйлдвэрт ашиглаж эхэлснээр үүсэх юм. Тухайн усыг ашиглахдаа скуббер, сэгсрэх ширээ, болон угаан баяжуулах үйлдвэрийн гол шат дамжлагуудад ашиглах бөгөөд үүгээр дамжуулан газар доор дарагдсан хөрсөнд агуулагдаж байсан уулын цул элементээр технологийн ус бохирдох магадлалтай. Энэхүү усыг ашиглаж байх хугацаанд байгальд нийлүүлэх хаягдал усны стандартаас давуулсан бохирдолттой хаягдал усыг шавхан зайлуулах нь Туул голын усан орчин, цаашилбал биологийн төрөл зүйлд нөлөөлөл үзүүлж болзошгүй юм.
- Төслийн үйл ажиллагаа явуулах хугацаанд баяжуулахын нууранд ашиглах усны эх үүсвэрийг уурхайн карьерт олборлолтын үед шүүрлээр орж ирэх усыг авч ашиглах ба угаан баяжуулалт хийсний дараах үед бохирын нуурт буюу технологийн эргэлтийн усан санд хуримтлагдаж буй усны түвшин хэвийн түвшнээс давсан тохиолдолд шавхан зайлуулалт хийх шаардлагатай болох ба үүнийг Туул голруу шавхан зайлуулалт хийхээр төлөвлөсөн байна. Энэхүү ажиллагааг хийхдээ шавхан зайлуулалт хийж буй хоолой голын эрэг, татаал хэсгээс давж усны түвшинд хүрээгүйн улмаас голын эрэг эвдрэх, улмаар голын урсгалд идэгдэн эргийн хэмжээ аажмаар өөрчлөгдөх нөлөөлөл үзүүлж болзошгүй байна.

3.4.Төслөөс агаар орчинд учруулах нөлөөлөл

- Уурхайн тээврийн зам. Уурхайн гол агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэг нь уурхайн тээврийн замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр замаас үүсэх тоосжилт юм.Уурхайн тээвэрлэлт нь овоолго тээврийн хүнд даацын тээвэр болон үйлчилгээний тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс бүрдэнэ. Тээврийн замаас үүсэх тоос,тоосонцрын ялгарлын хэмжээг АНУ-ын Байгаль орчныг Хамгаалах Агентлаг AP-42 section 13.2.2 Unpaved Road эх үүсвэрийн гарын авлагын аргазүйг ашиглан тооцоолов. Тээврийн зам дээрх тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нь тоосжилтын хамгийн гол эх үүсвэр бөгөөд уурхайн үйл ажиллагаанаас үүсэж байгаа нийт

тоос,тоосонцрын 80%-с илүүг үүсгэдэг.Үйлдвэр дотоод тээвэрлэлт нь овоолго болон хүдрийн бункер хооронд хийгдэх хүнд даацын тээврийн хэрэгслийн хөдөлгөөн юм.

- Ухаш олборлолт. Уурхайн үндсэн үйл ажиллагаа буюу олборлолт уурхайн ухаш дотор явагддаг.Уулын цулыг утгуурт ачигч буюу экскаватороор тээврийн хэрэгсэлд ачихад хялбар болгохын тулд уурхайн хүдэр болон хөрсний биетэд өрөмдөж тэсрэх бодисоор тэсэлгээ хийнэ.Тэсэлгээгээр суларсан хөрс,хүдрийг тээврийн хэрэгсэлд утгуурт ачигчаар ачина.Өрөмдлөг,тэсэлгээ,ухаж ачих,тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр агаарт тоосжилт үүснэ.
- Овоолго үүсэх. Ухаш олборлолтоор тээврийн хэрэгсэл уулын цулыг уурхайн овоолго дээр тээвэрлэж буулгана.Тээврийн хэрэгсэлээс овоолгод материал буулгахад болон овоолго үүсгэх автомеханизм болох бульдозерийн үйл ажиллагаар орчны агаарт тоос,тоосонцор ялгарна.
- Тээврийн хэрэгслийн түлшний шаталтаас үүсэх агаар бохирдуулагч. Тээврийн хэрэгслийн түлшний шаталтаас олон төрлийн агаар бохирдуулагч ялгардаг.Түлшний найрлаганд агуулагдах бодисууд болох хүхэр болон нүүрстөрөгч,дэгдэмхий органик нэгдлүүдээс шаталтаар агаарт хүхэрийн ислүүд,нүүрстөрөгчийн дан болон давхар ислүүд,метан болон метан агуулаагүй ууршимтгай органик,нэгдлүүд болон азотын ислүүд ялгардаг.

3.5.Төслөөс амьтны аймагт учруулах нөлөөлөл

Уурхайн хөрс хуулалт, шинээр овоолго, усан сан үүсгэх, ажилчдын хотхон барьж байгуулах үйл ажиллагааны нөлөөгөөр хөрсөнд орогнон амьдардаг жижиг мэрэгчид, шавж, бичил биетнүүд өртөж үхэх, тэдгээрийн амьдрах орчин нь сүйтгэгдэж тоо толгой нь буурах нөлөөлөл бий болно.

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

3.6. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ

Булган аймгийн Бүрэгхангай сумын нутагт хэрэгжихээр төлөвлөж буй MV-016841 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Туул голын баруун дэнж” алтны шороон ордыг ашиглах төслийн БОМТ-г Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А-618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулав.

Энэхүү БОМТ нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилготой юм.

3.7.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 30. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, Мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
Цаг уур, уур амьсгал									
1	Цаг уурын гэнэтийн, аюултай үзэгдлийн улмаас болзошгүй осол аваар гарах	Хүчтэй аадар бороо орох, хүчтэй салхилах, шороон шуурга шуурах зэрэг байгаль цаг уурын аюултай үзэгдлийн үед уурхайн олборлолт, тээвэрлэлт, ачилт буулгалтын үйл ажиллагааг түр зогсоох, техник хэрэгслүүдийг унтрааж, ажиллагааг зогсоох	Төслийн хэрэгжилтийн бүх үе шатанд, шаардлагатай үед	хон	Дотоод төлөвлөлт-өөр	35	-	09 сараас 10 сарын 15 хүртэлх хугацаанд	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 2008 он Машин механизмуудын аюулгүй ажиллагааны дүрэм
Агаарын чанар									
2	Уурхайн олборлолт, хөрсний овоолго болон тээврийн замаас тоосжилт үүсэх	Усалгааны машин ашиглан тоосжилт үүсгэж буй зам талбайг услах, усалгааг хур тунадасгүй хуурайшилт ихтэй үе болон тээвэрлэлт хийхийн өмнө гэсэн тохиромжтой цагуудад хийх	Төслийн үйл ажиллагаанд ашиглаж буй шороон зам дагуу	м ³	Ус ашиглалтын зардлаар	480	-	09 сараас 10 сарын 15 хүртэлх хугацаанд	Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага, агаарын чанарын стандарт MNS 4585:2016

3	Уурхайн тээврийн замаас тоосжилт үүсэх	Уурхайн дотоод замд хөрс, элс тээвэрлэх автосамосвалуудын хөдөлгөөний дундаж хурдыг 20-40 км/цаг байхаар хязгаарлаж анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ байршуулах	Уурхайн карьер, дотоод тээврийн зам, кемп-уурхайн чиглэл, карьер-баяжуулх	тоо	150.0	4	600.0	9-р сард	Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага, агаарын чанарын стандарт MNS 4585:2016
4	Уурхайн тээврийн замаас тоосжилт үүсэх	Тээвэрлэлт хийх автомашинуудын хоорондын зайг 20 секунд байхаар тогтоож замын ачаалалд хяналт тавих	Уурхайн карьер, зам, бусад хэсэгт	хон	Уурхайн дотоод хяналтын зардалд	35	-	09 сараас 10 сарын 15 хүртэлх хугацаанд	Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага, агаарын чанарын стандарт MNS 4585:2016
5	Уурхайн тээврийн замаас тоосжилт үүсэх	Замын маршрутыг тодорхой заасан мэдээлэх болон анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ байршуулах	Орон нутгийн зам болон уурхай бүс, уурхайн карьер-баяжуулах, баяжуулах-Овоолго	тоо	150.0	4	600.0	9-р сард	Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм MNS 4596 : 2014 Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага MNS 4597 : 2014

6	Уурхайд ашиглах техник хэрэгслүүдийн хөдөлгүүрээс ялгарах хийн төлөвт бохирдуулагчийн хэмжээ стандартын ЗДХ-ээс хэтэрч болзошгүй.	Уурхайд ашиглах бүх машин механизмуудыг жил бүр төлөвлөгөөт үзлэг оношилгоонд хамруулж, шаардлагатай тохиолдолд хөдөлгүүрийг сольж шинэчлэх, хаягдал утаа шүүгч катализатор суурилуулах замаар утааны ялгаруулалтыг бууруулах арга хэмжээ авах, засвар үйлчилгээг тогтмол хийх	Уурхайд ашиглах бүх машин механизмууд	Тоо	500.0	2	1,000.0	9 сард 10 сард	Зам, тээврийн сайдын 2013 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн 232 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулах журам, Дизель хөдөлгүүртэй автомашин-Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5014:2009
7		Ашиглалтын хугацаа дууссан, агаар бохирдуулагч хорт хийг стандартын ЗДХ-ээс хэтрүүлэн ялгаруулж буй машин механизмыг ашиглалтаас гаргах, холбогдох стандартуудыг мөрдөж ажиллах	Уурхайд ашиглах бүх машин механизмууд	тоо	900.0	1	900.0	9-р сард	Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598:2011
8		Агаарын бохирдлыг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлж буй ажлуудын бүртгэл (усалгааны хуваарь болон гүйцэтгэл, машин механизмуудын засварын бүртгэл, шинэчилж сайжруулсан тоног	Төсөл хэрэгжих хугацаанд	Тоо	20.0	5	100.0	9, 10-р сард	Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага, агаарын чанарын стандарт MNS 4585:2016

		төхөөрөмжийн акт, техникийн баримт бичиг, мониторингийн үр дүн, тайлан г.м), тайлан хөтөлж ТЖБОМТ болон түүний биелэлтийн тайланд үр дүнг тусгах							
Газрын гадарга, хөрсөн бүрхэвч									
9	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр олон салаа шинэ зам үүсч хөрс эвдрэх	Уурхайн дотоод тээврийн маршрут болон лицензийн талбайн орчмын замыг тэмдэгжүүлж, шинээр олон салаа зам үүсгэж хөрс эвдэхгүй байх	Уурхайн карьер, зам, бусад хэсэгт	м ²	Уулын мастерийн цалингийн зардалд	8,000	-	9, 10-р сард	Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм MNS 4596 : 2014 Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага MNS 4597 : 2014
10	Хог хаягдлаар хөрс бохирдох	Хатуу шингэн хаягдлын цэгүүдийг стандартын шаардлагад нийцүүлэн байгуулж хөрс бохирдохоос сэргийлэх	Төслийн үйл ажиллагаанд ашиглаж буй хогийн цэг	Тоо	250.0	2	500.0	9-р сард	Хог хаягдлын тухай хууль, 2017
11	Шатах тослох материалын хадгалалтын үед хөрс бохирдох	Шатах тослох материалыг зориулалтын дагуу стандартын шаардлага хангасан агуулахад хадгалах ба шатахууны агуулахын битүүмжлэлийг сайтар хангаж хөрс бохирдуулахаас сэргийлэх	Төслийн үйл ажиллагаа явуулах талбайд болон засварын талбай орчимд	м ²	-	315	500.0	9-р сард	Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850 : 2019
12		Тээврийн хэрэгслийг түлш, шатахуунаар цэнэглэх үед	Шатахуун түгээх	м	5.7	35	200.0	Үйл ажиллагаа явж байгаа	Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулах.

		шатах тослох материал асгарч, алдагдахаас сэргийлэн зориулалтын шингэн нэвтрэхгүй шатдаггүй материал дэвсэж хөрсөн бүрхэвч бохирдохоос сэргийлэх	байршил болгонд					тохиолдолд өдөр бүр дагаж мөрдөнө.	Технологийн байгууламж. Техникийн ерөнхий шаардлага MNS 5746 : 2007
13	Бүх төрлийн шатах, тослох материалаар ажилладаг машин механизм, тээврийн хэрэгслүүдийн ашиглалтын үед шатах тослох материал асгарч хөрс бохирдуулах	Шатах тослох материал их, бага ямар нэг хэмжээгээр асгарсан бол элс, даавуу зэрэг шингээгч материалд шингээн авч битүү саванд хийх, асгарсан хэсгийн хөрсийг хуулж аван хөрсний гүн рүү нэвчихээс сэргийлэх	Төсөл хэрэгжилтийн бүх үе шатанд	м ³	Уурхайн туслахын цалингийн зардлаар	Хуулж авсан хэмжээ-гээр тооцно	-	Тохиолдол гарсан тухай бүрт авч хэрэгжүүлнэ.	Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850 : 2019 Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүний агуулах. Технологийн байгууламж. Техникийн ерөнхий шаардлага MNS 5746 : 2007
14	Засварын талбайн хөрс ШТМ-аар бохирдох	Уурхайн авто засварын талбайг хатуу хучилттай болгох	Уурхайн засварын талбайд	м ²	16.6	30	500,00	9-р сард	Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850 : 2019
15		Уурхайн лицензийн талбайн хүрээнд мониторингийн цэгүүд байгуулж, хөрсний хими, физик шинж чанар, эрүүл ахуй, хүнд металлын бохирдлыг тодорхойлох хяналт шинжилгээг тогтмол хийх, шинжилгээний үр дүнг холбогдох стандартуудын	Жил бүр ОХШХ-т төлөвлөсөн хугацаанд	Тоо	Цалингийн зардлаар	7 дээж* 2 удаа = 14	-	ОХШХ-т заасан хугацаанд буюу улирал тус бүрт 1 удаа	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

		ЗДХ-тэй харьцуулан анализ хийх							
Гадаргын болон газрын доорх ус									
17	Газрын доорх шүүрлийн усыг үр ашиггүй зарцуулах	Уурхайн технологийн усыг гадаргын усаар хангах, ус ашиглахтай холбоотой дүгнэлт, зөвшөөрлийг холбогдох мэргэжлийн байгууллагаар гаргуулах	Ашиглалтын хугацаанд жил бүр	Тоо	БОМ-ийн зардлаар	1	-	9-р сард.	Усны тухай хууль, 2012 он
18	Усан сангуудын буруу төлөвлөлт, байгуулалтаас хамаарч усыг эргүүлэн ашиглах зорилгоо биелүүлж чадахгүйд хүрэх	Цэвэршүүлэх усан сан, бохирын болон тунаах нуурыг батлагдсан зураг төсөл, нормыг баримтлан байгуулж, технологийн усны 70 хувийг эргүүлэн ашиглах нөхцөлийг бүрдүүлэх	Төслийн үйл ажиллагааны шатанд	м ³	Уулын ажлын зардлаар	8,860	-	9-р сард.	Усны барилга байгууламжийн буурь БНБД 33-04-09”
19	Холбогдох дээд шатны байгууллагын зөвшөөрөлгүй гүний худаг гаргах	Ажилчдын унд ахуйн ус хэрэглээг хангах зориулалт бүхий гүний худаг гаргах зөвшөөрлийг аймгийн Байгаль орчны газраас авах	Төслийн үйл ажиллагааны шатанд	тоо	-	1	-	9-р сард.	Усны тухай хууль, 2012 он
20	Хууль эрх зүйн зөрчил үүсгэх	Гүний худгийг мэргэжлийн байгууллагаар гаргуулах ба худгийн паспортыг баталгаажуулан хаяж үрэгдүүлэхгүй хадгалах, гүний худгийн усны чанарыг тогтмол хянаж байх	Төслийн үйл ажиллагааны шатанд	тоо	217.0	1	217.0	9-р сард.	Усны тухай хууль, 2012 он Монгол Улсын байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн А-230/127 дугаар хамтарсан тушаал, “Усны

									сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам”
21	Усны үр ашиггүй зарцуулалт бий болох	Ус ашиглах хэсгүүдийг тоолууржуулж, үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалтаар хэрэглэсэн усны бүртгэл хөтлөх, ус хэрэглээнд хяналт тавих	Төслийн үйл ажиллагааны шатанд	тоо	250.0	3	750.0	Тоолуурыг 9-р сар байршуулж өдөр бүр хэрэгжүүлнэ.	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 5 дүгээр сарын 16-ны өдрийн, А-156 дугаар тушаал, Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам
22		Усны хяналтын тоолууруудыг баталгаажуулах	Төслийн үйл ажиллагааны шатанд	Тоо	үнэгүй	3	-	9-р сард.	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 5 дүгээр сарын 16-ны өдрийн, А-156 дугаар тушаал, Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам
23	Бүх төрлийн шатах тослох материалын ашиглалт, хадгалалт, алдагдлын үед хөрсний ус, хур тунадасны угаагдлаар дамжин гадаргын болон газрын доорх ус бохирдуулах	Машин техникийн аюулгүй ажиллагаа, бүрэн бүтэн байдлыг хангах, шаардлагатай үед засвар үйлчилгээг зориулалтын засварын газарт хийлгэх, шатах тослох материал алдагдсан бол нэн даруй элс, даавуунд шингээн авах эсвэл бохирдсон хөрс шороог гүн рүү нэвчихээс өмнө хүрээр хусаж авах	Төслийн үйл ажиллагааны шатанд	м ³	Уурхайн туслахын цалингийн зардлаар	Бохирдсон хэмжээгээр	-	Тохиолдол гарсан тухай бүрт авч хэрэгжүүлнэ.	Байгаль орчныг хамгаалах. Усан мандал. Гадаргын усны чанарыг хянах журам MNS 4047 : 1988 Усны чанар. Гүний усны бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх агууламж, MNS 6148:2010 Гүний усыг бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлагууд. MNS 3342:1982

24	-	Сумын Засаг даргатай эсхүл Сав газартай ус бохирдуулсны төлбөрийн гэрээ байгуулж, ус бохирдуулсны төлбөрийг хуулийн хугацаанд төлөх	Төслийн үйл ажиллагааны шатанд	м³	Дүгнэлт-д зааснаар	*	-	Хаягдал усны дүгнэлт, гэрээ, дүгнэгдсэн сарын 20-ны дотор	Усны тухай хууль, 2012 он
25	-	Хаягдал усны бүртгэлийг тогтмол хөтлөх	Төслийн үйл ажиллагааны шатанд	хон	Усны менежерийн цалингийн зардлаар	35	-	9, 10-р саруудад	
Ургамлан нөмрөг									
